

ХУНДЫН ХООЛОЙН ТАВДУГААР ДӨРВӨЛЖИН


2008 онд Монгол-Хятадын судалгааны анги Архангай аймгийн Хотонт сумын Хундын хоолойд археологийн малтлага явуулжээ.

Судалгааны баг Хундын хоолойн долоон дөрвөлжингийн хамгийн том нь болох 5-р Дөрвөлжинд малтлага хийж, малтлагын үр дүнд тоосгон бунхан илэрч, бунханы дотор хананд зурсан туурган зураг илэрсэн нь нэн сонирхолтой юм.

Зургийн үндсэн сэдэв нь цэцэг, ургамлын дүрст хээ бөгөөд улаан хүрэн, цагаан, хар өнгийн будгаар бадам цэцгийг олон давтамжтайгаар дурсэлжээ. Бадам цэцэг нь дорнын ард түмний дунд амар амгалангийн бэлгэдэл болдог. Тухайн зураг өнгө будгийн зохицол, дүрслэлийг харвал ихээхэн ур чадвартай үйлдсэн болох нь ажиглагдана. Уг зураг нь тухайн үеийн дүрслэх урлаг, уран зургийн түвшинг харуулах биет дурсгал болж байна.




Зураг 1. Хундын хоолойн 5 дугаар дөрвөлжингийн бунханы ханан дахь бадам цэцэгэн хээ.



Зураг 2. 3D байдлаар сэргээн төсөөлсөн загвар.



Зураг 3. Хоёр төрлийн алтан ээмэг, алтан товч ойролцоох бушинаас илэрсэн.



Зураг 4. Зоосны хагархай болон хүрэл эд хэрэглэл.



Зураг 5. Алтаар маш нарийн хийцтэй хийсэн “ЦОХ” хэмээх чимэглэл (ойролцоох булшнаас).

ДОМГИЙН АМЬТНЫ ДҮРСЛЭЛТЭЙ ВААР

2009 онд Монгол-Хятадын хамтарсан судалгааны ангийн судлаачид Архангай аймгийн Хотонт сумын Өвөрхавцалын амны зургаадугаар Дөрвөлжингийн малтлагаар илрүүлжээ. Ийм дүрслэлтэй шавар чимэглэлийн хагархай өмнө нь хэдэнтээ олдож байсан боловч хамгийн сайн хадгалагдсан, харьцангуй бүтэн нь уг олдвор болно.

Саарал өнгөтэй, нарийн ширхэгтэй шавраар ур хийц сайтай үйлдсэн, шатаалт сайтай. Түрэг угсаатнууд тахилын онгон, шүтээний сүмийн барилгын чимэглэлд догшин ширүүн төрхтэй, үлгэр домгийн сүрлэг амьтад болон чулуун арслан зэргийг үйлдэн тавьдаг байжээ. Энэ нь барилгыг чимэглэхийн сацуу шүтээний газар муу муухай зүйлийг оруулахгүй, хөөн зайлуулах гэсэн утга агуулгатай ажээ. **Өвөрхавцалын амны зургаадугаар Дөрвөлжингөөс гарсан энэхүү үзмэр нь урт төвгөр эвэр, түрэмгий догшин нүдтэй, хурц соёо бүхий сүрлэг амьтны**

дүрслэл бөгөөд Уйгурын нийслэл Харбалгас, ОХУ-ын Тувагийн Порбажын зэрэг VIII-IX зууны үеийн уйгурын хот суурингаас олддог байна.

Уг олдвор нь Түрэгийн үеийн барилгын чимэглэл болоод Хятадын Тан улсын чимэглэлүүдээс өвөрмөц ялгаатай ажээ. Энэ чимэглэлийг сүм дугана, барилгын багана, дээврийн уулзвар хэсэгт байршуулдаг байсан бололтой.



Зураг 6. Өвөрхавцалын амны 6 дугаар дөрвөлжингийн малтлагаас илэрсэн барилгын шавар чимэглэлүүд.



Зураг 7. Өвөрхавцалын амны 6 дугаар дөрвөлжингийн малтлагаас илэрсэн сүм дугана, барилгын багана, дээвэрт байрлуулдаг чимэглэл(хажуу талаас).



Зураг 8. Өвөрхавцалын амны 6 дугаар дөрвөлжингийн малтлагаас илэрсэн сүм дугана, барилгын багана, дээвэрт байрлуулдаг чимэглэл(ээц урд талаас).